



“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГэрын Даргын 2025 оны 01 дугээр сарын 07-ны өдрийн А/07 дугаар тушаалтын хавсралт

4248171 1921060002 ГСТ7201

## “ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН ЖОЛООЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Дагаж мөрдөх огноо: 2025-01-07

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2025-01-07

Байгууллагын нэр:

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ

Албан тушаалын нэр:

Жолооч

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нэхцэл:

Ердийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын байрны албан ёсны байршил:

Дархан уул аймаг, Дархан сум, 10 дугаар баг

Онцгой нэхцэл:

Байгууллагын болон хувь хүний нууц хадгалах, амралт, баяр ёслолын өдрүүдэд болон зарим үед ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллана.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

1. Байгууллагын үйл ажиллагааг гүйцэтгэхэд машин техникийн бүрэн бүтэн, бэлэн байдлыг хангах. Байгууллагын үйл ажиллагаа, газрын даргын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

Албан тушаалын зорилт:

1. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад авто машины техникийн бэлэн байдлыг хангах;  
2. Байгууллагын дотоод ажилд оролцох;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн, саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэн, авто машиныг ажилд гарахад бэлэн байлгах;</p> <p>2. Авто машины техникийн эд ангийн засвар, үйлчилгээг тогтмол хийж, эвдрэл гарсан тохиолдолд байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнуудад мэдэгдэн сэлбэг хэрэгслээр ханггуулж, засвар үйлчилгээг тогтмол хийлгэх.</p> <p>3. Авто машинд гарсан том, жижиг засвар гэмтлийг заавал мэдэгдэх, жижиг засварыг өөрөө хийх, засварын газраар хийлгэх тохиолдолд өртөг, тооцоог хянуулах.</p> <p>4. Машин техникийн өдөр тутмын арчилгаа, тосолгоог хийж, замын хөдөлгөөний болон хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангтан ажиллах;</p> <p>5. Өдөр бүрийн явах маршрутыг ерөнхий инженерээс тодруулан шаардах хуудас бичэн талоныг няраваас хүлээн авах;</p> <p>6. Өдөр бүр замын хуудсыг хөтлөн, ИТА, албан хаагчдаар дор бүр нь гарын үсгээр зуруулж баталгаажуулах.</p> <p>7. Сар бүрийн эцэст замын хуудсыг нягтлан бодогчоор хянуулан няравт хүлээлгэн өгөх.</p> <p>8. Тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын даатгалыг хугацаанд нь хийлгэх.</p>	Авто машины бэлэн байдлыг хангагдаж, байгууллагын үйл ажиллагаа жигд явагдана.	Г, Т
	<p>1. Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүрэг, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж, гүйцэтгэлийг тайлагнаж захирах, захирагдах ёсыг баримтлан ажиллах;</p> <p>2. Байгууллагын дүрэм, дотоод журам, ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллаж, ажлын цаг</p>		

2 дугаар зорилтын хүрээнд	<p>ашиглалт, хөдөлмөрийн сахилга батыг сахин ажиллах.</p> <p>3. Байгууллагаас зохион байгуулах сургалт, мэдээллийн цаг, спорт, урлагийн болон бусад нэгдсэн арга хэмжээнд идэвхтэй оролцох;</p> <p>4. Ажлын байранд хариуцсан эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, авто машины цэвэр цэмцгэр, эмх цэгтэй байдлыг хангаж ажиллах;</p> <p>5. Албаны бус зорилгоор байгууллагын машин, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, албаны мэдээллийг ашиглахгүй байх;</p> <p>6. Замын хуудсыг хугацаанд нь санхүүд хүргүүлэх.</p> <p>7. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг ажлын байранд болон зам, барилгын ажлын талбайд бүрэн өмсөж, хэрэглэх, ХАБЭА зааварчилгааг авч өдөр бүр гарын үсэг зурах.</p> <p>8. Ажил үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул ослын үед анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх.</p> <p>9. Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх.</p> <p>10. Галын аюулаас урьдчилан сэргийлэх.</p>	Байгууллагын үйл ажиллагаа жигд явагдана.	Г, Т, Ш
---------------------------	---	---	---------

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн дунд ба түүнээс дээш
Мэргэжил	Жолооч
Мэргэшил	В ангиллын жолооч
Туршлага	Мэргэжлээрээ 1-ээс дээш жил ажилласан туршлагатай
Үр чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Харьцааны соёлтой</li> <li>• Машин техникийн талаар мэдлэгтэй.</li> <li>• Багаар ажиллах чадвартай</li> <li>• Ажилдаа нягт нямбай ханддаг.</li> </ul>
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллага болон хувь хүний нууцыг хадгалах.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Албан тушаалд шууд харьялан удирдуулах  
албан тушаалын нэр, тоо:

1. Дарга
2. Ерөнхий инженер
3. Нягтлан бодогч
4. Ахлах инженер

Нийт 4

Бусад харилцах субъект

- 1.ИТА, албан хаагчид
- 3.Аймаг, сумдын ЗДТГ-ын  
мэргэжилтнүүд
- 4.Иргэн, хуулийн этгээд

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: Ерөнхий инженер

..... (У.ЗАЯАХҮҮ)

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 01 дүгээр сарын 07 -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ

Шийдвэрийн огноо: 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр

Дугаар: А/07

(тамга/тэмдэг)

ДАРГА : ..... (Д.БАТБАЯР)  
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр